

Барилга, хот байгуулалтын яамны  
Төрийн нарийн бичгийн даргын 2019 оны  
... дугаар сарын ... -ны өдрийн ...  
дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

**БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЯАМНЫ  
ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН БҮТЦИЙН  
НЭГЖИЙН ЧИГ ҮҮРЭГ**

Газар, хэлтсийн нэр	Үндсэн чиг үүрэг
<p><b>1.Төрийн захиргааны удирдлагын газар</b></p>	<ul style="list-style-type: none"> <li>• Төрийн захиргаа, хүний нөөцийн удирдлагын манлайллыг хангах;</li> <li>• салбарын ажиллах хүч, мэргэжилтний хэрэгцээг тодорхойлох, судалгаа хийх, мэдээллийн сан байгуулах, судалгааны үр дүнгээр яамны нэгж, удирдлага, бусад дээд шатны байгууллагыг мэдээллээр хангах;</li> <li>• салбарын төрийн албан хаагчдын хэрэгцээг тодорхойлох, хэтийн болон ойрын бодлогын хувилбар боловсруулах, чадавхийг дээшлүүлэх, мэргэшүүлэх, давтан сургах асуудлыг зохион байгуулах;</li> <li>• салбарын инженер техникийн ажилтнуудын чадавхийг дээшлүүлэх, мэргэшүүлэх, давтан сургах асуудлыг нэгдсэн зохион байгуулалтаар хангах;</li> <li>• барилгын салбарын хамтын хэлэлцээр байгуулах, хэрэгжилтийг хангах, хяналт тавих;</li> <li>• салбарын шагнал олгох асуудлыг зохион байгуулах;</li> <li>• иргэд, байгууллагаас ирүүлсэн өргөдөл, гомдол, санал хүсэлтийг хүлээн авах, шийдвэрлэх үйл ажиллагаанд хяналт тавих;</li> <li>• яамны гүйцэтгэлийн төлөвлөгөө болон ТЗУГ-ын гүйцэтгэлийн төлөвлөгөө нэгтгэн батлуулах, төлөвлөгөөний биелэлтийг нэгтгэх, архивын нэгж болгон хүлээлгэн өгөх;</li> <li>• салбарын үйл ажиллагааг хэвлэл, мэдээллийн хэрэгслээр сурталчлах;</li> <li>• яамны албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг нь хангах асуудлыг зохион байгуулах;</li> <li>• яамны дэргэдэх Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн үйл ажиллагааны хэтийн төлөвлөгөө, стратегийг тодорхойлох, түүний хэрэгжилтийг зохион байгуулах;</li> <li>• яамны интернет, дотоод сүлжээ, цахим хуудсын хэвийн ажиллагааг хангах, мэдээллийг тогтмол шинэчилж байх;</li> <li>• удирдлага, яамны аппаратын албан хаагчдыг шийдвэр боловсруулах, хэрэгжүүлэхэд мэргэжил арга зүйн зөвлөгөө, дэмжлэгээр хангах;</li> <li>• яамны архив, албан хэрэг хөтлөлтийг холбогдох хууль тогтоомж, стандарт, заавар журмын хүрээнд хөтлөх, эрхлэн явуулах;</li> <li>• Улсын Их Хурал, Засгийн газар, бусад төрийн захиргааны төв байгууллага болон холбогдох төрийн болон нутгийн захиргааны байгууллагуудтай харилцах ажлыг зохион байгуулах, шаардлагатай зөвлөгөө, мэдээллэр хангах;</li> <li>• сайдын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэх асуудлыг</li> </ul>

	<p>төлөвлөх, хэрэгжилтийг хангуулах, үр дүнг танилцуулах;</p> <ul style="list-style-type: none"> <li>• яамны шуурхай зөвлөгөөнийг зохион байгуулах, зөвлөгөөнөөс өгсөн үүрэг даалгаварын хэрэгжилтийг хангуулах;</li> <li>• яамны дотоод үйл ажиллагаа зохион байгуулах.</li> </ul>
	<ul style="list-style-type: none"> <li>• Салбарын хууль тогтоомжийн давхардал, хийдлийг судалж, зөрчлийг арилгах, шаардлагатай хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах санал боловсруулах зэргээр хууль тогтоомж, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын шийдвэрийн төсөл боловсруулах, салбарын эрх зүйн орчинг боловсронгуй болгох;</li> <li>• Улсын Их Хурал, Засгийн газар, бусад яамтай хамтран шийдвэрлэх болон дангаараа боловсруулж шийдвэрлэх асуудлыг боловсруулах, санал өгөх, явцын бүртгэл хөтөлж удирдлагыг мэдээллээр хангах;</li> </ul>
1.1.Хуулийн хэлтэс	<ul style="list-style-type: none"> <li>• хууль тогтоомж, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын шийдвэрээр өгөгдсөн үүрэг даалгаврыг хяналтад авч, хууль тогтоомж, гэрээ хэлэлцээр, захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэрийн бүртгэл хөтлөх, кодификаци хийх лавлагаа, мэдээллийн сан бүрдүүлэх;</li> <li>• сайд, Төрийн нарийн бичгийн даргын тушаалын төсөл боловсруулах, хууль зүйн зөвлөгөө өгөх, биелэлтэд хяналт тавих, биелэлтийг тайлагнах;</li> <li>• гэрээ, хэлэлцээр, бусад эрх зүйн баримт бичиг, салбарын норм дүрэм, стандартыг хууль тогтоомжид нийцэж байгаа эсэхийг хянаж, санал дүгнэлт гаргах, хууль зүйн зөвлөгөө өгөх;</li> <li>• яамны бүтцийн нэгжүүдээс бусад төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжид явуулж байгаа албан бичгийн хууль зүйн үндэслэлийг хянах, хууль зүйн зөвлөгөө өгөх;</li> <li>• хууль тогтоомж, нийтээр дагаж мөрдүүлэхээр гаргасан шийдвэрийг сурталчлах;</li> <li>• Улсын Их Хурал, Засгийн газар, төрийн захиргааны бусад төв байгууллагууд болон яамны хэмжээнд байгуулагдсан ажлын хэсэг, комисс, зөвлөл, хорооны бүртгэл хөтлөх, хариуцсан ажлын биелэлтийг холбогдох газруудаас нгэгтгэн удирдлагыг мэдээллээр хангах;</li> <li>• нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон Байгууллагын нууцын асуудлыг хууль тогтоомжийн хүрээнд хариуцан, Төрийн нууцын тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах;</li> <li>• яамны хууль ёсны эрх ашгийг итгэмжлэлийн үндсэн дээр хууль, шүүхийн байгууллагад төлөөлөх;</li> <li>• шүүхийн маргааны бүртгэл хөтөлж, удирдлагад танилцуулан, удирдлагыг мэдээллээр хангаж ажиллах;</li> <li>• хүний эрх, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, жендер, дайчилгааны асуудлыг хууль тогтоомжийн хүрээнд хариуцах;</li> </ul>
1.2.Санхүүгийн хэлтэс	<ul style="list-style-type: none"> <li>• Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгдсэн тайланг хагас бүтэн жилээр нэгтгэн гаргаж, Үндэсний аудитын газраар аудит хийлгэн баталгаажуулж, тайлагнах ажлыг зохион байгуулах;</li> <li>• Төсвийн тухай хууль болон бусад хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, урсгал болон хөрөнгө оруулалт, гадаадын зээл, тусламжийн хөрөнгийн эх үүсвэрийг дунд хугацаанд төлөвлөх, гүйцэтгэлийг баталгаажуулах, үр дүнгээр санхүүжүүлэх, нягтлан бодох бүртгэлд тусгах, тайлагнах;</li> </ul>

	<ul style="list-style-type: none"> <li>• салбарын төрийн сангийн өдөр тутмын гүйлгээг хянан баталгаажуулах, холбогдох мэдээ тайланг гаргах;</li> <li>• Шилэн дансы тухай хуулийн хэрэгжилтийг хангахад санхүүгийн мэдээ, мэдээллээр дэмжлэг үзүүлэх;</li> <li>• яамны төв аппаратын төсвийн урсгал зардлын эх үүсвэрийн төлөвлөлт, хуваарилах, үр ашигтай зарцуулах, яамны эд хөрөнгийн бүрэн бүтэн байдалд хяналт тавих тайлагнах дотоод аж ахуйн үйл ажиллагааг зохион байгуулах.</li> </ul>
	<ul style="list-style-type: none"> <li>• Гадаад хамтын ажиллагааны бодлого, чиглэлийг салбарын үйл ажиллагааны стратегитэй уялдуулан тодорхойлж, хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх ажлыг санаачлан зохион байгуулах, хөрөнгө оруулалт татах, технологи оруулах зэрэг ажлуудад дэмжлэг үзүүлэх;</li> </ul>
1.3. Гадаад хамтын ажиллаганы хэлтэс	<ul style="list-style-type: none"> <li>• салбарын гадаад хамтын ажиллагааг удирдлага, чиглэл, зөвлөмжөөр хангаж, гадаад арга хэмжээг нэгтгэн, нэг цонхны бодлого баримталж ажиллах;</li> <li>• Засгийн газар хоорондын комиссын хуралдаанууд, зөвлөлдөх болон дугуй ширээний уулзалтууд, дээд, өндөр түвшний айлчлалууд, стратегийн түншлэлийн хөтөлбөр, хамтын ажиллагааны урт, дунд хугацааны хөтөлбөрүүд, эдийн засгийн түншлэлийн хэлэлцээр зэрэг хоёр болон талт хамтын ажиллагааны механизмуудад салбарын хамтын ажиллагаа, хөрөнгө оруулалт, төсөл хөтөлбөрүүдийн саналыг тухай бүх хэлэлцүүлэх, тусгуулах, хэрэгжүүлэх ажилд дэмжлэг үзүүлэх;</li> <li>• яам, харьяа байгууллагуудын удирдлагуудын айлчлал, уулзалтууд, албан хаагчдын гадаад томилолтыг зохион байгуулах.</li> </ul>
	<ul style="list-style-type: none"> <li>• Хот байгуулалт, газрын харилцаа, геодези, зураг зүй, барилга, барилгын материалын үйлдвэрлэл, орон сууц, нийтийн аж ахуйн /цаашид бүхэлд нь “салбарын” гэх/ талаар төрөөс баримтлах бодлогыг төлөвлөх, тодорхойлох, боловсруулах, мэргэжлийн зөвлөгөө өгөх, хяналт тавих;</li> <li>• салбарын бодлогыг Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал, Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хууль болон бусад холбогдох салбаруудын хөгжлийн бодлого, төлөвлөлттэй уялдуулах;</li> <li>• салбарын норм, нормативын тогтолцоог бүрдүүлэх, хууль, эрх зүйн орчинг боловсронгуй болгох, санал боловсруулж шийдвэрлүүлэх;</li> </ul>
2.Бодлого төлөвлөлтийн газар	<ul style="list-style-type: none"> <li>• салбарын төсөл, хөтөлбөр боловсруулахад тооцоо, судалгаа хийх, мэргэжлийн удирдамж, чиглэлээр хангах;</li> <li>• салбарын баримт бичиг боловсруулахад нийгэм, эдийн засгийн мэдээлэл, тооцоо, судалгаа шинжилгээгээр хангах, норм, дүрэм журам, стандартыг боловсруулахад мэргэжлийн удирдамж, чиглэлээр хангах;</li> <li>• салбарын суурь судалгаа, статистик мэдээллийг нэгтгэж, мэдээллийн сан бүрдүүлэх, тогтмол баяжилт хийх, салбарын үйл ажиллагаанд дүн шинжилгээ хийх;</li> <li>• салбарт хэрэгжиж буй төсөл хөтөлбөр, арга хэмжээ, судалгааны болон шаардлагатай мэдээллийн сан байгуулах, судалгааны үр дүн, салбарт болон холбогдох мэдээллээр удирдлага, яамны нэгж, бусад холбогдох байгууллагыг мэдээллээр хангах;</li> <li>• салбарын шинжлэх ухаан, техник, технологийн дэвшилтэт арга, технологийн ололтыг зураг төслөөр дамжуулан хэрэгжүүлэх, бодлогын баримт бичиг, төсөл хөтөлбөрт</li> </ul>

	<p>тусгуулах, баримт бичгийн чанарын түвшинг дээшлүүлэхэд мэргэжлийн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх;</p> <ul style="list-style-type: none"> <li>• норм, нормативыг боловсруулах ажлыг зохион байгуулж, батлуулах, хэрэгжилтийг хангуулах;</li> <li>• шинээр батлагдсан барилгын норм, дүрэм, стандартыг сурталчлах, сургалт зохион байгуулах;</li> <li>• олон улсын стандарт, норм нормативын баримт бичгийг судлах, өөрийн оронд нэвтрүүлж, нутагшуулах талаар судалгаа хийх;</li> </ul>
	<ul style="list-style-type: none"> <li>• барилга байгууламжийн норм, нормативын санг бүрдүүлэх, зарцуулах болон сангийн үйл ажиллагаанд мэргэжил арга зүйн зөвлөгөө, бодлогын удирдамж, чиглэлээр хангах;</li> <li>• барилга байгууламжийн норм, нормативын сангийн хөрөнгийг салбарын хууль тогтоомж, норм, нормативын баримт бичгийг боловсруулах, судлах, сурталчилах, хэвлэн олшруулах болон эдгээрийг зохион байгуулах үйл ажиллагаа удирдлага, зохицуулалтаар хангах;</li> <li>• холбогдох төрийн болон нутгийн захиргааны байгууллагуудтай өөрийн хариуцсан чиглэлээр нягт хамтран ажиллах, бодлогын чиглэл, удирдамжаар хангах, шаардлагатай тооцоо, судалгаа, мэдээ, мэдээллийг түргэн шуурхай авч, мэдээлэл байнга солилцож ажиллах;</li> <li>• салбарын бодлогын хувьд холбогдох төрийн болон нутгийн захиргааны байгууллагуудын салбар дундын зохицуулалтыг хангах;</li> <li>• салбарын ногоон хөгжлийн бодлогыг төлөвлөж, тодорхойлох ажлыг удирдан зохион байгуулах;</li> <li>• яамны стратеги төлөвлөгөөг боловсруулж, батлуулах, төлөвлөгөөний биелэлтийг хангуулах, нэгтгэх.</li> </ul>
	<ul style="list-style-type: none"> <li>• Монгол Улсын Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хууль, салбарын хөгжлийн бодлоготой уялдуулан гадаадын түнш донор орон, Олон улсын байгууллагын шугамаар төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх санал боловсруулж, шийдвэрлүүлэх, хэрэгжилтийг зохион байгуулах;</li> <li>• хөрөнгө оруулалтын бодлого, зохицуулалтаар хангах, үйлдвэрлэл, үйлчилгээний хөгжлийн стратегийг боловсруулах;</li> <li>• салбарын хөрөнгө оруулалт, үйлдвэрлэлийн урт, дунд хугацааны стратеги, холбогдох хууль тогтоомж, хөтөлбөр төсөлд эдийн засгийн үр өгөөжийн дүн шинжилгээ хийх, бүтээмж үр дүнг тооцож, санал боловсруулах, бодлогын удирдамжаар хангах;</li> </ul>
2.1.Хөрөнгө оруулалт, үйлдвэрлэлийн хэлтэс	<ul style="list-style-type: none"> <li>• хууль тогтоомж, бодлого, урт, дунд хугацааны стратеги, хөтөлбөр, төслийг эдийн засгийн дүн шинжилгээ хийх, бүтээмж, үр дүнг тооцох;</li> <li>• салбарын хөрөнгө оруулалт, үйлдвэрлэлийн мэдээллийн сан бий болгох, тогтмол шинэчлэх, мэдээллээр дээд байгууллага, удирдлага, яамны нэгжүүдийг хангаж ажиллах;</li> <li>• орон сууц, нийтийн аж ахуйн салбарт хэрэгжиж буй төсөл, хөтөлбөрийг удирдлага, зохицуулалтаар хангах, зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх;</li> <li>• орон сууц, нийтийн аж ахуйн салбарт шинээр хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрийн тооцоо судалгаа хийж, санал боловсруулах;</li> <li>• салбарт хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөр, хөрөнгө оруулалтын гүйцэтгэлд хяналт-шинжилгээ хийх санал боловсруулах;</li> <li>• салбарт хэрэгжүүлэх шаардлагатай төсөл, арга хэмжээний</li> </ul>

	<p>санхүүжилтийг гадаад болон дотоод эх үүсвэрээс шийдвэрлүүлэх ажлыг зохион байгуулах;</p> <ul style="list-style-type: none"> <li>• салбарын хэмжээний төсвийн гүйцэтгэл, хөрөнгө оруулалтын явц, санхүүгийн нөөцийн зарцуулалтад хяналт тавих, санхүүгийн тайланг нэгтгэх, дүнг тайлагнах;</li> <li>• барилга, хот байгуулалтын сайд/ТЕЗ/-ын багцын төсөв, түүний тодотгол, харьяа газруудын орлого, зарлагын төлөвлөгөөг ооловсруулан батлуулах, төсвийн тухай хуулийг хэрэгжүүлэхэд мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх салбарын статистик мэдээллийг нэгтгэн боловсруулж удирдлага, хэрэглэгчдийг мэдээллээр хангах;</li> <li>• байгаль орчинд ээлтэй, эко үйлдвэрлэлийг урамшуулах механизмыг боловсруулж, хэрэгжүүлэх,</li> <li>• ногоон хөгжлийн бодлого, шинэ дэвшилтэт технологи, инновацид суурилсан салбарын үйлдвэрлэлийг хөрөнгө оруулалтын бодлогоор дэмжих, санал боловсруулах;</li> <li>• салбарын хөрөнгө оруулалт, үйлдвэрлэлийн мэдээллийн сан бий болгох, тогтмол шинэчлэх, мэдээллээр дээд байгууллага, удирдлага, яамны нэгжүүдийг хангаж ажиллах.</li> </ul>
	<ul style="list-style-type: none"> <li>• Хот байгуулалт, архитектур, газрын харилцаа, геодези, зураг зүйн талаар төрөөс баримтлах бодлого, хууль, дүрэм, журам, норм, стандартын төсөл боловсруулах, санал өгөх, тэдгээрийн хэрэгжилтийг хангах;</li> <li>• хот байгуулалт, архитектур, газрын харилцаа, геодези зураг зүйн салбарын бодлого, төсөл хөтөлбөр, төлөвлөлтийн бүх үе шатны баримт бичиг боловсруулахад нийгэм, эдийн засгийн тооцоо, мэдээлэл, судалгаа шинжилгээ, судалгаагаар хангах, мэргэжлийн зөвлөгөө, удирдамжаар хангах;</li> <li>• хот байгуулалт, архитектур, газрын харилцаа, геодези зураг зүйн салбарт хэрэгжиж буй төсөл хөтөлбөр, төлөвлөлтийг удирдлага, зохицуулалтаар хангах, мэргэжлийн удирдлага, зөвлөгөө, дэмжлэгээр хангах, хэрэгжилтэнд хяналт тавих;</li> <li>• хот байгуулалт, газрын харилцаа, геодези, зураг зүйн салбарт шинээр хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрийн тооцоо судалгааг санал боловсруулах;</li> <li>• хот байгуулалтын хөгжлийн төсөл, хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулахад улс орны нийгэм эдийн хөгжлийн, ногоон хөгжлийн бодлого болон бусад холбогдох салбаруудын хөгжлийн бодлоготой уялдуулах;</li> </ul>
<p><b>3. Хот байгуулалт, газрын харилцааны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар</b></p>	<ul style="list-style-type: none"> <li>• газар зохион байгуулалтын төлөвлөлт, газрын нэгдмэл сангийн ашиглалт, хамгаалалт, газар өмчлөл, газрын зах зээлийн талаар төсөл, хөтөлбөр боловсруулах, хэрэгжилтийг хангах;</li> <li>• хот байгуулалт, архитектур, газрын харилцаа, геодези зураг зүйн салбарын суурь судалгаа, статистик мэдээллийг нэгтгэж гаргах, холбогдох байгууллага, иргэдийг мэдээ, мэдээллээр хангах, салбарын чиглэлээр бодлогын баримт бичиг боловсруулахад ашиглах;</li> <li>• хот байгуулалт, архитектур, газрын харилцаа, геодези зураг зүйн салбарын төрийн болон төрийн бус байгууллагуудын үйл ажиллагааг удирдлага зохицуулалтаар хангах, зөвөлгөө дэмжлэг үзүүлэх;</li> <li>• хот байгуулалт, газрын харилцаа, геодези, зураг зүйн чиглэлээр боловсруулагдаж буй төсөл хөтөлбөр бусад холбогдох баримт бичигт яамны холбогдох нэгжтэй болон дангаараа үнэлэлт, дүгнэлт өгч тогтмол судалгаа хийх;</li> <li>• нэгж дээр хэрэгжиж буй бодлого, төсөл хөтөлбөр, судалгааны</li> </ul>

	<p>талаарх мэдээллийн сан байгуулах, судалгааны үр дүнгээр яамны нэгж, удирдлага, бусад дээд шатны байгууллагыг мэдээллээр хангах;</p> <ul style="list-style-type: none"> <li>хот байгуулалт, архитектур, газрын харилцаа, геодези зүйн шинжлэх ухаан, техник, технологийн дэвшилтэт арга, технологийн ололтыг зураг төслөөр дамжуулан хэрэгжүүлэх, бодлогын баримт бичиг, төсөл хөтөлбөрт тусгуулах, баримт бичгийн чанарын түвшинг нэмэгдүүлэхэд мэргэжлийн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх;</li> </ul>
	<ul style="list-style-type: none"> <li>холбогдох төрийн болон нутгийн захиргааны байгууллагуудтай өөрийн хариуцсан чиглэлээр нягт хамтран ажиллах, бодлогын чиглэл, удирдамжаар хангах, шаардлагатай тооцоо, судалгаа, мэдээ, мэдээллийг түргэн шуурхай авч байх, мэдээлэлээр байнга солилцож байх;</li> </ul>
	<ul style="list-style-type: none"> <li>тусгай зөвшөөрөл, түүнтэй холбоотой үйл ажиллагааг боловсронгуй болгох, олгох ажлыг зохион байгуулах, тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээдийн үйл ажиллагаанд нэгжийн зүгээс мэргэжлийн талаас хяналт тавих, мэргэжил, арга зүйн зөвлөгөөгөөр хангах.</li> </ul>
<p><b>4.Барилга, барилгын материалын үйлдвэрлэлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар</b></p>	<ul style="list-style-type: none"> <li>Барилгын салбарт төрөөс баримтлах бодлого, хууль тогтоомж, дүрэм, журам, норм, стандартын төсөл боловсруулах ажлыг зохион байгуулах, санал өгөх, тэдгээрийн хэрэгжилтийг хангах, зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх;</li> <li>барилгын салбарт хэрэгжиж буй төсөл, хөтөлбөрийг мэргэжлийн удирдлага, зохицуулалтаар хангах, зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх;</li> <li>барилгын салбарт шинээр хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрийн тооцоо судалгаа хийх, санал боловсруулах;</li> <li>барилгын хатуу хог хаягдлын менежмент, агаарын бохирдлыг бууруулах, ногоон хөгжлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах;</li> <li>салбарын суурь судалгаа, статистик мэдээллийг нэгтгэж, мэдээллийн сан бүрдүүлэх, тогтмол баяжилт хийх, холбогдох дээд байгууллага, удирдлага, яамны бүтцийн нэгж, иргэдийг мэдээ, мэдээллээр хангах, бодлогын баримт бичиг боловсруулахад ашиглах;</li> <li>барилгын салбарын төрийн болон төрийн бус байгууллагуудын үйл ажиллагааг зохицуулалтаар хангах, зөвлөгөө дэмжлэг үзүүлэх;</li> </ul>
	<ul style="list-style-type: none"> <li>салбарын байгууллагуудын үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах талаар санал, зөвлөмж боловсруулах, хэрэгжилтийг хангах;</li> <li>нэгж дээр хэрэгжиж буй бодлого, төсөл хөтөлбөр, судалгааны талаарх мэдээллийн сан байгуулах, судалгааны үр дүнгээр яамны нэгж, удирдлага, бусад дээд шатны байгууллагыг мэдээллээр хангах;</li> <li>салбарын үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл олгох ажлыг зохион байгуулах, мэргэжил, арга зүйн зөвлөгөө, дэмжлэгээр хангах;</li> <li>салбарын холбогдох байгууллагуудтай хамтран тогтмол судалгаа хийх, судалгааны үр дүн болон хэрэгжүүлсэн ажлын талаар хагас жил тутамд дүн шинжилгээ хийж яамны нэгж, удирдлага, бусад дээд шатны байгууллагыг мэдээллээр хангах;</li> <li>Хот суурин, барилга байгууламжийн инженер геологи, геотехник, хайгуул судалгааны чиглэлээр хэрэгжүүлэх бодлого, хөтөлбөр, төслийн санал боловсруулах, хэрэгжилтийг хангах,</li> </ul>

	<p>гадаад, дотоодын төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллах;</p> <ul style="list-style-type: none"> <li>• барилга байгууламжийн цахилгаан хангамж, холбоо дохиоллын системд шинэ дэвшилтэт техник, технологи нэвтрүүлэх, сэргээгдэх эрчим хүчийг ашиглах чиглэлээр санал боловсруулах, норм, дүрэм, стандартын хэрэгжилтийг зохицуулалтаар хангах, зөвлөгөө дэмжлэг үзүүлэх;</li> </ul>
	<ul style="list-style-type: none"> <li>• барилгын чанар, аюулгүй ажиллагаа, хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны горим зөрчсөн осол, аваарын талаар бүртгэл хөтлөх, мэдээллийн сан байгуулах, шалтгаан нөхцлийг судлах, осол, аваарыг бууруулах талаар санал боловсруулах, хэрэгжилтийг хангуулах;</li> </ul>
	<ul style="list-style-type: none"> <li>• барилга байгууламжийн хийц, бүтэц, эдлэхүүн, материал, түүхий эдийн бат бэх чанар, аюулгүй байдлын үзүүдэлтийг тодорхойлох, техник технологийг туршин шалгаж, дүгнэлт гаргах чиг үүрэг бүхий нэгдсэн лабораторийг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж ажиллах;</li> <li>• газар хөдлөлийн чиглэлээр салбарын холбогдох хууль тогтоомж, бодлого, хөтөлбөр, төслийн боловсруулах, хэрэгжилтийг хангах, газар хөдлөлийн гамшгийн эрсдэлийг бууруулах чиглэлээр гадаад, дотоодын төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллах;</li> <li>• хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн чиглэлээр холбогдох яам, агентлагтай хамтран ажиллах, нэгдсэн бодлого, хөтөлбөр, төсөл боловсруулах, мэргэжлийн удирдамж, чиглэл, зөвлөгөө, дэмжлэгээр хангах, хэрэгжилтийг хангах;</li> <li>• барилга байгууламжийн зураг төсөлд магадлал хийх ажлыг мэргэжлийн удирдамж, чиглэлээр хангах.</li> </ul>
<p><b>5.Инженерийн дэд бүтцийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар</b></p>	<ul style="list-style-type: none"> <li>• инженерийн дэд бүтцийн салбарын хууль тогтоомж, бодлого, хөтөлбөр, төслийн хэрэгжилтийг зохион байгуулах, зохицуулах</li> <li>• инженерийн дэд бүтцийн уялдаа холбоог зохицуулах, хууль тогтоомж, хөтөлбөр, төслийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, зохицуулах;</li> <li>• инженерийн дэд бүтцийн норм, нормативын баримт бичгийг боловсронгуй болгох, батлуулах ажлыг зохион байгуулах, зохицуулах;</li> <li>• инженерийн дэд бүтцийн салбарын мэдээллийн сан бүрдүүлэх, боловсронгуй болгох ажлыг зохион байгуулах, зохицуулах;</li> <li>• салбарын бодлогын хэрэгжилтийг зохион байгуулан зохицуулах, зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх;</li> <li>• салбарын суурь судалгаа, статистик мэдээллийг нэгтгэж, мэдээллийн сан бүрдүүлэх, хэрэглэгчийг мэдээллээр хангах;</li> <li>• сайд, дэд сайд, Төрийн нарийн бичгийн дарга, зохион байгуулалтын бүтцийн нэгж, холбогдох байгууллагуудыг стратегийн бодлого боловсруулахад дэмжлэг үзүүлэх, бодлогын хувилбар боловсруулах, шаардлагатай мэдээлэл, зөвлөгөө, бүх талын дэмжлэгээр хангах.</li> </ul>
<p><b>6.Нийтийн аж ахуйн бодлогын хэрэгжилтийг</b></p>	<ul style="list-style-type: none"> <li>• Орон сууц, нийтийн аж ахуйн салбарт төрөөс баримтлах бодлого, хууль, тогтоомж, дүрэм, журам, норм, стандартын төсөлд санал өгөх, тэдгээрийн хэрэгжилтийг удирдлага, зохицуулалтаар хангах, зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх;</li> <li>• агаарын бохирдлыг бууруулах, ногоон хөгжлийн бодлого, тогтвортой хөгжлийн үзэл баримтлалын хэрэгжилтийг зохицуулах;</li> <li>• салбарын суурь судалгаа, статистик мэдээллийг нэгтгэн гаргах, холбогдох байгууллага, иргэдийг мэдээ, мэдээллээр хангах,</li> </ul>

<p><b>зохицуулах газар</b></p>	<p>салбарын чиглэлээр бодлогын баримт бичиг боловсруулахад ашиглах;</p> <ul style="list-style-type: none"> <li>• орон сууц, нийтийн аж ахуйн салбарын төрийн болон төрийн бус байгууллагуудын үйл ажиллагааг удирдлага зохицуулалтаар хангах, зөвлөгөө дэмжлэг үзүүлэх;</li> <li>• салбарын байгууллагуудын үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах талаар санал, зөвлөмж боловсруулах, хэрэгжилтийг удирдлага зохицуулалтаар хангах;</li> </ul>
	<ul style="list-style-type: none"> <li>• салбарын байгууллагуудын өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангуулах, тайлан, мэдээг нэгтгэн боловсруулах, холбогдох байгууллагуудын мэдээ мэдээллээр хангах, тулгамдсан асуудлыг шийдвэрлүүлэх;</li> <li>• нэгж дээр хэрэгжиж буй бодлого, төсөл хөтөлбөр, судалгааны талаарх мэдээллийн сан байгуулах, судалгааны үр дүнгээр яамны нэгж, удирдлага, бусад дээд шатны байгууллагыг мэдээллээр хангах;</li> </ul>
<p><b>7.Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар</b></p>	<ul style="list-style-type: none"> <li>• Барилга, хот байгуулалт, газрын харилцаа, орон сууц, нийтийн аж ахуйн салбарын хууль тогтоомж, бодлого, хөтөлбөр, төлөвлөгөө, төслийн хэрэгжилтийн явцад хяналт- шинжилгээ хийж, үр дүнд нь үнэлгээ өгөх;</li> <li>• хууль тогтоомж, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын шийдвэр, Сайд, Төрийн нарийн бичгийн даргын тушаалын хэрэгжилтийн явц, үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, холбогдох санал, зөвлөмжөөр хангах;</li> <li>• яамны эрхлэх асуудлын хүрээнд улсын төсөв, гадаадын зээл, буцалтгүй тусламжийн хөрөнгөөр санхүүжигдэж буй төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийж, үр дүнд нь үнэлгээ өгөх;</li> <li>• яамны эрхлэх асуудлын хүрээний агентлаг, байгууллагын үйл ажиллагааны үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит хийх;</li> <li>• Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх Үндсэн чиглэл, ногоон хөгжлийн бодлого, тогтвортой хөгжлийн үзэл баримтлал, барилга, хот байгуулалтын сайдын эрхлэх асуудлын хүрээнд тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилтийн явц, үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх;</li> <li>• Төсвийн ерөнхийлөн захирагчтай Төсвийн шууд захирагч /Төрийн нарийн бичгийн дарга/, Төсвийн ерөнхийлөн захирагчаас агентлаг, харъяа байгууллагын дарга нартай байгуулсан үр дүнгийн гэрээ, үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийх, зөвлөмжөөр хангах.</li> </ul>
	<ul style="list-style-type: none"> <li>• яамны дотоод бүтцийн нэгжүүдийн үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийж, зөвлөмж өгөх;</li> <li>• яамны сар, улирал, хагас бүтэн жилийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайлан, хүрсэн түвшинд хяналт-шинжилгээ хийж, үр дүнд нь үнэлгээ өгөх, дүгнэлт зөвлөмж гарган удирдлагад танилцуулах, Засгийн газрын тайлангийн нэгдсэн санд холбогдох тайлан, мэдээллийг байршуулах, тайлагнах;</li> <li>• яамны бараа, ажил, үйлчилгээ, худалдан авах ерөнхий төлөвлөгөөний хэрэгжилтэд дотоод аудит хийх;</li> <li>• төсвийн тухай хуульд заасны дагуу яам, агентлаг, харъяа байгууллагын зарим үйл ажиллагаанд дотоод аудит хийж, дүгнэлт зөвлөмж гарган эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах;</li> <li>• сайдын багцын санхүүгийн нэгдсэн тайлан харъяа</li> </ul>



	<p>байгууллагын санхүүгийн үйл ажиллагаа, улсын төсвийн хөрөнгө оруулалтын хэрэгжилтэд Үндэсний аудитын газраас хийсэн аудитын зөвлөмжийн биелэлтийг хангуулах;</p> <ul style="list-style-type: none"> <li>• шилэн дансны тухай хуулийн дагуу санхүүгийн гүйлгээнд сар, улирал, хагас, бүтэн жил тутам хяналт тавьж, цахимаар Сангийн яаманд хүргүүлж, баталгаажуулах;</li> <li>• төсөв, санхүүгийн холбогдолтой хууль тогтоомж, дүрэм, журам, стандарт, гэрээг мөрдөж ажилласан эсэхэд ниццлийн дотоод аудит хийж, үнэлгээ, зөвлөмж өгөх;</li> </ul>
	<ul style="list-style-type: none"> <li>• салбарын үйл ажиллагааны үр дүнгийн зөвлөмж, мэдээллээр яамны бүтцийн нэгжүүдийг хангах.</li> </ul>

----- о 0 о -----